



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2019 оны 10 сарын 02 өдөр

Дугаар Б/48

Ховд

М.Буяндэлгэрийг ажлаас чөлөөлөх тухай

“Төрийн албаны тухай” хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.4; “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай” хуулийн 3 дугаар зүйлийн 3.3; 3.3.5 дахь заалт, Монгол улсын Засгийн газрын 1994 оны 212 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Нийгмийн даатгалын шимтгэл төлснөөр тооцогдох хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлөх журам”-ын 2 дахь хэсгийн “е”, мөн Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”-ын 3-ын 8 болон 4 дэх хэсэг, Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гаргахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам”-ын 3.1.5; 3.1.8; 3.3 дахь хэсэг, Монгол улсын Дээд шүүхийн Хяналтын шатны Захиргааны хэргийн шүүхийн 2015 оны 90 дүгээр тогтоолын ТОГТООХ нь хэсгийн 1, Нийгмийн даатгалын Ерөнхий газрын Дотоод аудит, мониторингийн газрын даргын 2019 оны 7/110 тоот албан бичиг, “Ховд аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, Төрийн сангийн хэлтсийн дүрэм”-ийн 2.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, эдийн засгийн бодлого зохицуулалтын хэлтсийн Өмч хариуцсан мэргэжилтэн М.Буяндэлгэрийг 2016 оны 8 дугаар сарын 01-ний өдрөөс төрийн албанаас чөлөөлөгдсөнд тооцсугай.

2. М.Буяндэлгэрийг Төрийн албанаас үндэслэлгүйгээр халагдсаныг шүүхээр нэгэнт эгүүлэн тогтоосон тул уг шалтгаанаар ажилгүй байсан хугацааг төрийн албанд ажилласан хугацаанд оруулж, захиргааны чөлөө эдэлж эхэлсэн 2009 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2016 оны 07 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацааны нийгмийн даатгалын шимтгэлийг 2008 онд захиргааны чөлөө авах

2019 г. Б/44 Сн

үедээ авч байсан цалин 448267 төгрөг /дөрвөн зуун дөчин найман мянга хоёр зуун жаран долоон/-нөөс тооцон, нөхөн төлж, Нийгмийн даатгалын дэвтэрт бичилт хийлгэхийг Санхүү, аж ахуйн тасгийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч Б.Нямдэлгэрт зөвшөөрсүгэй.

3.Төрийн албанаас чөлөөлөгдсөн М.Буяндэлгэрт 3 сарын цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэлэг 1344801 төгрөг /нэг сая гурван зуун дөчин дөрвөн мянга найман зуун нэгэн/ олгосугай.

4.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын “Нэг удаагийн тэтгэлэг олгох тухай” 2015 оны А/39 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Д.ЭНХБОЛД